



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

**ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ**

2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар 107

Улаанбаатар хот

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

*(Энэ тогтоолын хавсралтад Засгийн газрын 2020 оны 101 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон.)*

2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД У.ХҮРЭЛСҮХ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ